

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

---

2007 оны 11 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

“Урт хугацааны сайн дурын даатгалын  
хэлбэрийн жагсаалт”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл болон 14.2.15 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Урт хугацааны сайн дурын даатгалын хэлбэрийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчилж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## УРТ ХУГАЦААНЫ САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ХЭЛБЭРИЙН ЖАГСААЛТ

д/д	Даатгалын ангилал	Даатгалын хэлбэр
1	Урт хугацааны даатгал	Хуримтлалын (Endowment)
2		Насан туршийн (Whole life)
3		Хугацаат амьдралын (Term life)
4		Тэтгэврийн (Pension)
5		Эрүүл мэндийн даатгал (Private health insurance)

### **\*Урт хугацааны сайн дурын даатгалын хэлбэрүүдийн нэр томъёоны тайлбар:**

**Хуримтлалын даатгал (Endowment)** гэдэгт даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгагчаас даатгуулагч, эсвэл гэрээнд заагдсан эрх бүхий этгээдэд баталгаатай мөнгөн төлбөрийг төлөх хугацаат даатгал болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгалыг;

**Насан туршийн даатгал (Whole life)** гэдэгт даатгуулагч зөвхөн нас барсан нөхцөлд даатгагчаас даатгалын гэрээнд заагдсан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг;

**Хугацаат амьдралын даатгал (Term life)** гэдэгт зөвхөн даатгалтай хугацаанд даатгуулагч нас барсан нөхцөлд даатгагчаас даатгалын гэрээнд заагдсан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг;

**Тэтгэврийн даатгал (Pension)** гэдэгт даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгагчаас даатгуулагчид мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг (аннуйти хамаарна);

**Эрүүл мэндийн даатгал (Private health insurance)** гэдэгт эрүүл мэндийн холбогдолтой зардлыг 1 жилээс дээш хугацаа бүхий даатгалын гэрээгээр даатгагчаас даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгалыг (хөдөлмөрийн чадвар алдалт хамаарна).